



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 10 сарын 16 өдөр

Дугаар А/2023

Улаанбаатар хот

**Гал түймрийн аюулаас урьдчилан
сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Шадар сайдын 2023 оны “Гэр хорооллын айл өрхүүдийн галын аюулгүй байдлыг хангуулах урьдчилан сэргийлэх хяналт шалгалт зохион байгуулах удирдамж”, “Эрсдэлгүй Улаанбаатар” нөлөөллийн аяны удирдамжийн хүрээнд дүүргийн 1, 2 дугаар хорооны гэр хорооллын айл өрхүүдийг болзошгүй гал түймэр, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтыг 2023 оны 10 дугаар сарын 16-ны өдрөөс 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулж ажиллахыг Онцгой байдлын хэлтэс (Б.Цогбадрах)-т үүрэг болгосугай.

2. Урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг нэгдүгээр, хяналт шалгалт, урьдчилан сэргийлэх ажлын хуваарийг хоёрдугаар, шаардагдах хөрөнгийн төсвийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын ажлыг зохион байгуулахад шаардагдах 4.657.500 (дөрвөн сая зургаан зуун тавин долоон мянга таван зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД


Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны 10 дүгээр сарын 16 ны өдрийн
18 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



ХЯНАЛТ ШАЛГАЛТ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хийж гүйцэтгэх ажил	Хугацаа	Хамтран ажиллах байгууллага
1	Зохион байгуулагдах ажлын төлөвлөгөө боловсруулж батлуулах	2023.10.16	Онцгой байдлын хэлтэс
2	Нэгдсэн арга хэмжээнд шаардлагатай анонс, тараах материалыг бэлтгэх	2023.10.16- 2023.10.18	Онцгой байдлын хэлтэс
3	Дүүргийн 1, 2 дугаар хорооны гэр хорооллын байршилд өдөрлөг арга хэмжээ зохион байгуулж иргэдээр гал унтраах дадлага хийлгэх	2023.10.16- 2023.10.17	Онцгой байдлын хэлтэс 1, 2 дугаар хорооны ажлын алба, Улаан загалмайн хороо
4	Дүүргийн 1, 2 дугаар хорооны гэр хорооллын айл өрхүүдэд урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээлэл хүргэж, санамж материал тараах	2023.10.16- 2023.10.25	Онцгой байдлын хэлтэс 1, 2 дугаар хорооны ажлын алба
5	Гал түймрийн улсын хяналт шалгалтыг ажлыг зохион байгуулан албан бичиг хүргүүлж, зөрчил дутагдлыг арилгуулах	2023.10.16- 2023.10.25	Онцгой байдлын хэлтэс 1, 2 дугаар хорооны ажлын алба
6	Гал түймэр, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх төрөл бүрийн мэдээлэл, шторк, сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол хүргэж ажиллах	2023.10.16- 2023.10.25	Онцгой байдлын хэлтэс 1, 2 дугаар хорооны ажлын алба
7	1, 2 дугаар хорооны айл өрхүүдэд хөдөлгөөнт ухуулга сурталчилгааг давтамжтайгаар хүргэх ажлыг зохион байгуулах	2023.10.16- 2023.10.25	Онцгой байдлын хэлтэс
8	Багахангай дүүргийн 2 дугаар хорооны 20 өрхөд тагтай үнсний сав өгөх ажлыг зохион байгуулах	2023.10.23- 2023.10.24	Онцгой байдлын хэлтэс 2 дугаар хорооны ажлын алба
9	Зохион байгуулсан ажлын дүн, мэдээг 2023 оны 10 дугаар сарын 18-ны дотор дүүргийн Засаг даргад илтгэх хуудсаар танилцуулах	2023.10.30	Онцгой байдлын хэлтэс

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны 10 дүгээр сарын 16 ны өдрийн
103 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



**ХЯНАЛТ ШАЛГАЛТ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
АЖЛЫН ХУВААРЬ**


Д/д	Урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах бүрэлдэхүүн	Галын аюулаас урьдчилан сэргийлэх ажлын хугацаа		Нийт
		Эхлэх	Дуусах	
1.	Гал түймрийн улсын хяналтын байцаагч, Гал түймэр унтраах, аврах 80 дугаар ангийн бэлтгэл ээлжийн алба хаагчид Дүүргийн 1, 2 дугаар хорооны ажлын алба	2023.10.16	2023.10.25	10 хоног
Нийт (удаа)				

Тайлбар:

Бүрэлдэхүүн нь өдөр бүр 13-15 цагийн хооронд хяналт шалгалт, галын аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, ажлын мэдээг Онцгой байдлын хэлтэст ирүүлнэ.

Онцгой байдлын хэлтсийн Үндсэн албаны гал унтраах автомашинууд болон шуурхай албаны автомашинуудтайгаар, хяналт шалгалт, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна.

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны дүгээр сарын ны өдрийн
дугаар захирамжийн гуравдугаар хавсралт



УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛД ШААРДАГДАХ ТӨСӨВ

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	
1	Анонс 2 ш	20,1м ²	25,000	502,500	
2	Тараах материал	Объектын гал түймэр	500ш	1800	900,000
		Ой, хээрийн түймэр	500ш	1800	900,000
		Цахилгааны аюулгүй байдал	500ш	1800	900,000
3	Гал унтраагуур	7ш	65,000	455,000	
4	Тагтай үнсний сав /поошик/	20ш	50,000	1,000,000	
Нийт				4,657,500	